

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/003/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор Д.Цэрэнханд Утас: 99086371 Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2025/003/НА-СТА-
ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.04.04 № 137

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6-т, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд 14,330.0 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,
- Санхүүгийн ажилтанд санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж ажилласан үндэслэлээр 2 сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлж урамшуулал олгосон,

- Цалингийн зардлын дүн нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 3,960.1 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Тайлант онд автомашины урсгал засварт 12,951.5 мянган төгрөгийг зарцуулсан,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг батлагдсан төсвөөс 4,630.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,
- Ур чадварын нэмэгдлийг тушаалгүйгээр 5,633.6 мянган төгрөгийг илүү олгосон,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас цагдаагийн газарт 6,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдүүлгийн өрөөний завсарт 15,000.0 мянган төгрөгийн урсгал засвар хийгдсэн боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 оны тайланг хурлаар хэлэлцүүлэн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон.

Тайлант онд Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгууль зохион байгуулсан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчөөр 2020-2024 онд ажилласан төлөөлөгчид хүндэтгэл үзүүлэхэд 5,660.0 мянган төгрөгийг зарцуулсан

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийг тухайн чиг үүрэг бүхий байгууллагуудын нэмэлт дансанд шилжүүлсэн байна.

Бусад асуудал

Тайлант онд 6 зорилго 11 зорилт 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 90.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П. ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	60,816,710.00	31,413,448.00
33	АВЛАГА	30,815,440.00	609,948.00
33500	Бусад авлага	30,815,440.00	609,948.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	30,815,440.00	609,948.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,001,270.00	30,803,500.00
35400	Хангамжийн материал	30,001,270.00	30,803,500.00
35410	Бичиг хэргийн материал	105,000.00	105,000.00
35420	Аж ахуйн материал	27,935,290.00	29,337,250.00
35440	Түлш, шатах тослох материал	1,960,980.00	-
35450	Барилгын засварын материал	-	1,361,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	153,859,664.01	112,750,165.78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	153,859,664.01	112,750,165.78
39200	Биет хөрөнгө	153,849,664.01	112,610,165.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,000,000.00	215,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(148,263,889.12)	(178,055,555.80)
39205	Машин тоног тэхөөрөмж(компьютер)	110,131,822.00	118,493,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,790,487.21)	(55,711,653.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,540,660.00	27,014,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,768,441.66)	(14,499,415.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	368,500.00
39300	Биет бус хөрөнгө	10,000.00	140,000.00
39301	Програм хангамж	300,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(290,000.00)	(60,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	214,676,374.01	144,163,613.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	32,460,829.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	32,460,829.34
41300	Өглөг	-	32,460,829.34
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	32,460,829.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	214,676,374.01	111,702,784.44
51	Засгийн газрын хувь оролцоо	214,676,374.01	111,702,784.44
51100	Засгийн газрын оруулсан капитал	122,211,354.00	122,211,354.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	122,211,354.00	122,211,354.00
51200	Хуримтлагдсан үр дүн	89,868,911.18	(13,104,678.39)
51210	Өмнөх үеийн үр дүн	105,332,830.51	59,663,419.18
51220	Тайлант үеийн үр дүн	(15,463,919.33)	(72,768,097.57)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,596,108.83	2,596,108.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	214,676,374.01	144,163,613.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,247,191,500.00	1,262,618,060.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,740,000.00	7,248,860.00

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

120	Нийтлэг татварын бус орлого	18,740,000.00	7,248,860.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,740,000.00	7,248,860.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,955,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,740,000.00	5,293,860.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,228,451,500.00	1,255,369,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,000,000.00	54,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,000,000.00	14,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,000,000.00	40,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,118,451,500.00	1,201,369,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,118,451,500.00	1,201,369,200.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,198,655,419.33	1,335,386,157.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,198,655,419.33	1,335,386,157.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	783,850,465.67	929,308,236.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,243,900.08	537,714,655.74
210101	Үндсэн цалин	225,359,950.95	345,122,523.13
210102	Нэмэгдэл	109,542,701.39	174,465,857.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,557,248.92	18,126,275.46
210104	Урамшуулал	11,783,998.82	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,496,618.76	55,472,265.30
210201	Тэтгэврийн даатгал	32,239,156.86	38,601,022.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,574,372.13	4,267,310.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,867,231.09	2,100,655.41
210204	Ажилгүйдлийн даатгал	710,314.43	2,100,655.41
210205	Эрүүл мэндийн даатгал	7,105,544.25	8,402,621.64
2104	Хангамж, бараа материалын зардал	40,385,828.50	36,806,235.42
210401	Бичиг хэрэг	6,019,800.00	5,954,000.00
210402	Тээвэр, шатахуун	23,039,020.00	26,960,306.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,327,008.50	3,819,779.42
210404	Ном, хэвлэл	8,000,000.00	72,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,999,900.00	12,074,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,230,000.00
210604	Урсгал засвар	9,999,900.00	10,844,750.00
2107	Томилолт, зочны зардал	21,126,300.00	24,040,000.00
210702	Дотоод албан томилолт	21,126,300.00	24,040,000.00

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**


2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,846,069.00	151,791,532.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	207,846,069.00	148,136,680.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	205,852.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	405,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,751,849.33	111,408,798.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,161,000.00	19,550,000.00
210902	Хичээл үйлдээрлэлийн дадлага хийх	35,726,950.00	30,635,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,863,899.33	61,222,898.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	414,804,953.66	406,077,920.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	403,571,825.00	379,638,282.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	403,571,825.00	379,638,282.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,511,000.00	24,577,557.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	22,477,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,511,000.00	2,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,722,128.66	1,862,081.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,722,128.66	1,827,081.88
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	35,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	48,536,080.67	(72,768,097.57)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	64,000,000.00	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	64,000,000.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(15,463,919.33)	(72,768,097.57)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,228,451,500.00	1,257,324,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,000,000.00	55,955,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,000,000.00	14,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,000,000.00	40,000,000.00

ГАА-2025/003/НА-СТА-ТШЗ



**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,955,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,118,451,500.00	1,201,369,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,118,451,500.00	1,201,369,200.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,146,752,500.00	1,242,005,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,146,752,500.00	1,242,005,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,947,546.34	835,927,779.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,243,900.08	505,253,826.40
210101	Үндсэн цалин	225,359,950.95	312,661,693.79
210102	Нэмэгдэл	109,542,701.39	174,465,857.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,557,248.92	18,126,275.46
210104	Урамшуулал	11,783,998.82	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,496,618.76	55,472,265.30
210201	Тэтгэврийн даатгал	32,239,156.86	38,601,022.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,574,372.13	4,267,310.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,867,231.09	2,100,655.41
210204	Ажилгүйдлийн даатгал	710,314.43	2,100,655.41
210205	Эрүүл мэндийн даатгал	7,105,544.25	8,402,621.64
2104	Хангамж, бараа материалын зардал	42,346,808.50	34,845,255.42
210401	Бичиг хэрэг	6,019,800.00	5,954,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	24,999,326.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,327,008.50	3,819,779.42
210404	Ном, хэвлэл	8,000,000.00	72,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,999,900.00	14,339,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,230,000.00
210604	Урсгал засвар	9,999,900.00	13,109,000.00
2107	Томилолт, зочны зардал	21,126,300.00	24,040,000.00
210702	Дотоод албан томилолт	21,126,300.00	24,040,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	206,846,069.00	150,791,532.00

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,846,069.00	147,136,680.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	3,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	205,852.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	405,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,887,950.00	51,185,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,161,000.00	19,550,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	36,726,950.00	31,635,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	414,804,953.66	406,077,920.88
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	403,571,825.00	379,638,282.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	403,571,825.00	379,638,282.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,511,000.00	24,577,557.00
213204	Ажил олгогчдоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	22,477,557.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,511,000.00	2,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,722,128.66	1,862,081.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,722,128.66	1,827,081.88
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	35,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	81,699,000.00	15,318,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	81,699,000.00	15,318,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	81,699,000.00	15,318,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	81,699,000.00	15,318,500.00
223001	Бусад хөрөнгө	64,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,699,000.00	15,318,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(81,699,000.00)	(15,318,500.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	141,792,455.51	266,599,918.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(36,459,625.00)	(36,459,625.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	105,332,830.51	230,140,293.34
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(15,463,919.33)	(15,463,919.33)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	89,868,911.18	214,676,374.01
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	89,868,911.18	214,676,374.01
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(30,205,492.00)	(30,205,492.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	59,663,419.18	184,470,882.01
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(72,768,097.57)	(72,768,097.57)
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	122,211,354.00	2,596,108.83	(13,104,678.39)	111,702,784.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,253,112.50	1,199,542.12	53,570.38	95.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,112.50	1,199,542.12	53,570.38	95.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	848,534.50	795,326.28	53,208.22	93.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,253.90	505,253.83	0.07	100.00
210101	Үндсэн цалин	481,900.00	312,661.69	169,238.31	64.88
210102	Нэмэгдэл	23,353.90	174,465.86	(151,111.96)	747.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	18,126.28	(18,126.28)	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,147.60	55,472.27	8,675.33	86.48
210201	Тэтгэврийн даатгал	43,620.40	38,601.02	5,019.38	88.49
210202	Тэтгэмжийн даатгал	5,131.80	4,267.31	864.49	83.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,565.90	2,100.66	465.24	81.87

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210204	Ажилгүйдлийн даатгал	2,565.90	2,100.66	465.24	81.87
210205	Эрүүл мэндийн даатгал	10,263.60	8,402.62	1,860.98	81.87
2104	Хангамж, бараа материалын зардал	34,880.00	34,845.26	34.74	99.90
210401	Бичиг хэрэг	5,980.00	5,954.00	26.00	99.57
210402	Тээвэр, шатахуун	25,000.00	24,999.33	0.67	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,820.00	3,819.78	0.22	99.99
210404	Ном, хэвлэл	80.00	72.15	7.85	90.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,493.00	28,487.50	5.50	99.98
210601	Багаж, техник хэрэгсэл	16,554.00	16,548.50	5.50	99.97
210604	Урсгал засвар	11,939.00	11,939.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	24,040.00	24,040.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	24,040.00	24,040.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	154,604.00	110,791.53	43,812.47	71.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,946.00	107,136.68	43,809.32	70.98
210803	Даатгалын үйлчилгээ	3,000.00	3,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	208.00	205.85	2.15	98.97
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45.00	44.00	1.00	97.78
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405.00	405.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,116.00	36,435.90	680.10	98.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,225.00	19,550.00	675.00	96.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,891.00	16,885.90	5.10	99.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	404,578.00	404,215.84	362.16	99.91
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	380,000.00	379,638.28	361.72	99.90
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	380,000.00	379,638.28	361.72	99.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,578.00	24,577.56	0.44	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	22,478.00	22,477.56	0.44	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100.00	2,100.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,253,112.50	1,199,542.12	53,570.38	95.73
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,253,112.50	1,199,542.12	53,570.38	95.73
320001	Орон нутгийн төсвөөс	1,253,112.50	1,199,542.12	53,570.38	95.73

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө
-----	----------	-----------------------

ГАА-2025/003/НА-СТА-ТШЗ



1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,955,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,955,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,920,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,170,000.0
210604	Урсгал засвар	1,170,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,000,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,000,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,750,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,750,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,955,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,955,000.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	14,750,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,000,000.0
120004	төсөвт байгууллагын өөрийн орлого	1,205,000.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 1,000.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Хэлбэлзэл 1,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 70,145.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 70,145.6 мянган төгрөгийн 8 зөрчил илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Тайлант онд 14,330.0 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байрлсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно"-

гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

2. Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 1,980.0 мянган төгрөгөөр илүү урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-т /Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид нийцүүлэн цалин хөлсийг олгож байх зөрчлийг арилгаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн

3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчөөр 2020-2024 онд ажилласан төлөөлөгчид хүндэтгэл үзүүлэхэд 5,660.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжид нийцүүлэн төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж байх ажиллах албан шаардлага хүргүүлсэн

4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг батлагдсан төсвөөс 4,630.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зардлыг санхүүжүүлж байх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

5. Ур чадварын нэмэгдлийг тушаалгүйгээр 5,633.6 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмын 2-т /Төрийн

үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч шийдвэрлэнэ/ гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ур чадварын нэмэгдлийг ажил дүгнээгүй, тушаалгүй олгосон ажиллах албан шаардлага хүргүүлсэн

6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас цагдаагийн газарт 6,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдүүлгийн өрөөний завсарт 15,000.0 мянган төгрөгийн урсгал засвар хийгдсэн боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.6-д /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/ гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн бүртгэлийн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэх ажиллах албан шаардлага хүргүүлсэн

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд автомашины урсгал засварт 12,951.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2-т "Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүдийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллахыг автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөсүгэй; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар нормыг тогтоож, шаардлагатай сэлбэг эд ангийг техникийн комисс томилж, дүгнэлт гаргаж зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлын дүн нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 3,960.1 мянган төгрөгөөр зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах,

тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин, нийгмийн даатгалын зөрүүг арилгаж, тооцоо нийлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

(мянган төгрөгөөр)

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Хэлбэлзэл 1,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	1,000.0	1	1,000.0	-	-	1	1,000.0	-	-	-	-
	Дүн	1	1,000.0	1	1,000.0	-	-	1	1,000.0	-	-	-	-

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

(мянган төгрөгөөр)

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Тайлант онд 14,330.0 мянган төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй.	1	14,330.0	-	-	1	14,330.0	-	-	-	-	
	Санхүүгийн ажилтанд хууль тогтоомжид зааснаас 1,980.0 мянган төгрөгөөр илүү урамшуулалт цалин олгосон.	1	1,980.0	-	-	1	1,980.0	-	-	-	-	
	Цалингийн зардлын дүн нийгмийн даатгалын тайлангийн дүнгээс 3,960.1 мянган төгрөгөөр зөрүүтэй.	1	3,960.1	-	-	-	-	-	1	3,960.1	-	-
	Тайлант онд автомашины урсгал засварт 12,951.5 мянган төгрөгийг зарцуулсан	1	12,951.5	-	-	-	-	-	1	12,951.5	-	-
	Аймгийн Иргэдийн төлөөлөгчөөр 2020-2024 онд ажилласан төлөөлөгчид хүндэтгэл үзүүлэхэд 5,660.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	5,660.0	-	-	1	5,660.0	-	-	-	-	
	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг батлагдсан төсвөөс 4,630.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан	1	4,630.4	-	-	1	4,630.4	-	-	-	-	
	Ур чадварын нэмэгдлийг тушаалгүйгээр 5,633.6 мянган төгрөгийг илүү олгосон	1	5,633.6	-	-	1	5,633.6	-	-	-	-	
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас цагдаагийн газарт 6,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдүүлгийн ерөөний завсарт 15,000.0 мянган	1	21,000.0	-	-	1	21,000.0	-	-	-	-	

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

төгрөгийн урсгал засвар хийгдсэн боловч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.										
дүн	8	70,145.6	-	-	6	53,234.0	2	16,911.6	-	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		